

Төсөл
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2021 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

ҮРИЙН ТЕХНОЛОГИЙН НӨӨЦӨД БАЙХ ТАРИМЛЫН ТӨРӨЛ, НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ, УДИРДАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар зөвхөн үйлдвэрлэлд тариалагдах таримлын үрийн нөөц бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, зарцуулах, сортын аж ахуй, биологийн шинж чанарыг хадгалах, сайжруулах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Үрийн технологийн нөөц гэж хүлээгдэж байгаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зориулан бүрдүүлсэн таримал ургамын үрийн нөөцийг хэлнэ.

1.3. Таримлын үрийн технологийн нөөцийн үйл ажиллагаа нь дараах хоёр чиглэлтэй байна.

- а) Үрийн сорт солилт,
- б) Үрийн шинэчлэлт,

1.4. Үрийн сорт солилт гэж үйлдвэрлэлд тариалагдаж байгаа сортыг ургац, технологийн болон биологийн шинж чанараар давуу өөр шинэ сортоор солихыг хэлнэ.

1.5. Үрийн шинэчлэлт гэж биологийн нас хөгширсөн үрийг залуу настай шинэ үрээр солихыг хэлнэ. Технологийн залуу үр гэж 2 ба түүнээс цаашхи репродукцийн үрийг хэлнэ.

Хоёр. Удирдах үйл ажиллагаа

2.1. Ургамлын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээлийн болон технологийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг үндэслэн технологийн нөөцөд бүртгэх таримлын төрөл, зүйл, сортын жагсаалтыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр шинэчлэн батлана.

2.2. Технологийн нөөцөд Монгол Улсад болон гадаад оронд бүтээгдэж манай орны бүс нутгийн уур амьсгал, хөрс, цаг агаарын нөхцөлд эрх бүхий байгууллагын хяналтан дор соригдож туршигдан, нутагшсан болон ирээдүйтэй сорт, эрлийзээр батлагдсан, тухайн жилдээ Монгол Улсад тариалагдаж үр нь боловсорсон таримлын сортын үрийг бүртгэнэ.

2.3. Технологийн нөөцөд бүртгэгдсэн таримлын үр, сортыг нөөцлөх хэмжээг тогтоох, түүнийг бүрдүүлэх, хадгалах иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлыг аймгийн Хөдөө аж ахуйн газар хариуцан гүйцэтгэнэ.

2.4. Технологийн нөөцөд бүрдүүлсэн үрийн хэмжээг таримлын төрөл, зүйл, сорт бүрээр нарийвчлан гаргасан тайланг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч нэгтгэн Засгийн Газарт танилцуулна.

2.5. Технологийн нөөцөд бүрдүүлсэн үрийг хадгалах, сэлгэх хугацаа нь үр тариа, тэжээлийн олон наст өвслөг таримлынх 3 жил хүртэл, тос, техникийн таримал, даршны таримлынх 2 жил хүртэл, төмс, үндэс үрт хүнс ба тэжээлийн таримлынх 1 жил байна.

2.6. Технологийн нөөцөд бүрдүүлсэн үрийн нөөцийг зарцуулах хуваарийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр гаргаж батлана.

Гурав. Хяналт тавих

3.1. Технологийн нөөцөд бүрдүүлж байгаа үрийг тээвэрлэх, ачих, буулгах, хүлээн авах, агуулахад байрлуулах, хадгалах үйл ажиллагаа, үрийн чанарт хяналт тавьж дүгнэлт гаргах зэргийг “Үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх, зарцуулах журам”-аар зохицуулна.

3.2. Технологийн нөөцөд бүрдүүлсэн үрийн чанар, эрүүл ахуйн байдалд Улсын мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

Дөрөв. Санхүүжилт

4.1. Технологийн нөөцөд үр худалдан авах, тээвэрлэх, арчлах, хадгалах, борлуулахтай холбогдож гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4.2. Үрийг борлуулах үнэ нь худалдаж авсан үнэ дээр тээврийн зардал, хадгалах хугацааны туршид гарсан арчлалт, хадгалалтын зардлыг оролцуулан 20 хувиас илүүгүй нэмэгдэлтэй тогтоогдоно.